



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2024 оны 01 сарын 17 өдөр

Дугаар А/26

Улаанбаатар хот

Магадлан итгэмжлэл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/503 дугаар тушаалын 3.1 дэх хэсэг, Магадлан итгэмжлэх зөвлөлийн 2024 оны 1 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын нэрсийг хавсралтаар баталж, батламжийг олгосугай.

2. Магадлан итгэмжлэлийн хугацаанд тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулж, шинжээчдийн багийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2024 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн нэгдүгээр хурлын шийдвэрийг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (С.Эрдэнэтуяа)-т, Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа)-д тус тус даалгасугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналтын газар (С.Сүнчин)-т даалгасугай.

САЙД



С.ЧИНЗОРИГ

141240144

Эрүүл мэндийн сайдын 2024 оны
01 сарын 17 - ны өдрийн 4/26
дугаар тушаалын хавсралт

МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН
БАЙГУУЛЛАГЫН НЭРС

№	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	Батламжийн дугаар	Магадлан итгэмжлэгдсэн хугацаа	Магадлан итгэмжлэл	
				Эхлэх огноо	Дуусах огноо
1.	Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэг, Мараната өрхийн эрүүл мэндийн төв	01/2024	3 жил	2024.02.11	2027.02.11
2.	Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэг, Нэмүүлэн өрхийн эрүүл мэндийн төв	02/2024	4 жил	2024.01.22	2028.01.22
3.	Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэг, Буянт манал өрхийн эрүүл мэндийн төв	03/2024	1 жил	2024.01.17	2025.01.17
4.	Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэг, Мандам өрхийн эрүүл мэндийн төв	04/2024	2 жил	2024.01.22	2026.01.22
5.	Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэг, Мөнхбадрах өрхийн эрүүл мэндийн төв	05/2024	3 жил	2024.01.22	2027.01.22
6.	Улаанбаатар хотын Чингэлтэй дүүрэг, Нандин хүсэл өрхийн эрүүл мэндийн төв	06/2024	1 жил	2024.01.17	2025.01.17
7.	Улаанбаатар хотын Баянгол дүүрэг, ЦТАМ ХХК-ийн эмнэлэг	07/2024	1 жил	2024.01.17	2025.01.17
8.	Улаанбаатар хотын Чингэлтэй дүүрэг, Корсан ХХК-ийн эмнэлэг	08/2024	2 жил	2024.02.07	2026.02.07
9.	Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэг, Апекс менежмент ХХК-ийн Сон медикал центр-Улаанбаатар эмнэлэг	09/2024	1 жил	2024.01.17	2025.01.17
10.	Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэг, Цу-Эрдэнэ ХХК-ийн эмнэлэг	10/2024	2 жил	2024.02.11	2026.02.11
11.	Баян-Өлгий аймаг, Баяннуур сумын эрүүл мэндийн төв	11/2024	1 жил	2024.01.17	2025.01.17
12.	Дорнод аймаг, Гурванзагал сумын эрүүл мэндийн төв	12/2024	2 жил	2024.02.11	2026.02.11
13.	Увс аймаг, Мөнхбишрэлт өрхийн эрүүл мэндийн төв	15/2024	2 жил	2024.01.20	2026.01.20
14.	Увс аймаг, Малчин сумын эрүүл мэндийн төв	14/2024	3 жил	2024.01.20	2027.01.20
15.	Увс аймаг, Ховд сумын эрүүл мэндийн төв	13/2024	2 жил	2024.01.20	2026.01.20